



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XX Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 78

Эрдэнэ-Уул

Хоршоо хөгжүүлэх сангийн тухай

Сумын ЗДТГ-ын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтний танилцуулсан “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн үйл ажиллагааны тухай хэлэлцээд Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361, 2022 оны А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн эцсийн үлдэгдэл 152,254,669 төгрөгийг 2022 оны эх үүсвэрээр, 2023 онд олгох зээлийн хэмжээг 150,000,000 төгрөгөөр тус тус баталсугай.

2.2023 онд олгох зээлийн нэг жилийн хүү болох 4,500,000 төгрөгийн 50 хувь буюу 2,250,000 төгрөгийн 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, эргэн төлөлтөд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажилд зориулан Хоршоо хөгжүүлэх сангийн зөвлөл, хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулахыг сумын Засаг дарга (Л.Төмөрчөдөр)- т үүрэг болгосугай.


3.Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2023 онд олгох зээлийн хэмжээг 40,000,000 хүртэл төгрөгөөр, 36 хүртэл сарын хугацаагаар олгож байхаар тус тус тогтоосугай.

4.“Сумын хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги, төлөвлөлтийн дагуу “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн шинэчлилсэн журмыг нэгдүүгээр, тэргүүлэх чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Хоршоог хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг баримталж, сумын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулан хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангаж хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (Г.Энхтамир)-д даалгасугай.

6.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд даалгасугай.

ДАРГА  Т.БААСАНСҮРЭН



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2022 оны 6 сарын 9 ны өдрийн 78-р
тогтоолын 7 хавсралт



Хоршоог хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл

1. Барилгын материал үйлдвэрлэл
2. Хөнгөн үйлдвэрлэл /оёдол, сүлжмэл, нэхмэл/
3. Хүнсний үйлдвэрлэл
4. Шингэн бүтээгдэхүүний сав баглаа боодлын үйлдвэрлэл
5. Нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх үйлдвэрлэл
6. Ахуй үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэл
7. Инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл
8. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл
9. Мал бордох аж ахуй